



**АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139

Утас/Факс: (976) 7033 3231,

Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,

Цахим хуудас: www.arkhangai.gov.mn


2025.06.20 № 04/907

танай 2025.04.24-ны № ХТ/1122-Т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ**

Нээлттэй засгийн түншлэл санаачилгын хүрээнд “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног-2025” арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлын тайланг хүргүүлж байна.


Хавсралт.1 хуудастай

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  Ш.ГОМБОДОРЖ



652500900904

Аймгийн Засаг даргын тамгын газрын
даргын 2025 оны 06 дугаар сарын 20-ны
өдрийн 04 дүгээр албан бичгийн хавсралт



**“НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ - 2025”
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН АЖЛЫН ТАЙЛАН**

Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулж буй “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног - 2025” арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар АГХУСАЗСЗ-тэй хамтран “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” соён гэгээрүүлэх сарын аяныг зарласан. Тус аяны хүрээнд:

Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй хэн бүхэнд “ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЭЭД ӨӨРЧИЛБЕ”. Авлигад үгүй гэж хэлье уриатайгаар “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 6 төрлийн гарын авлага, 5 төрлийн брошюрыг олон нийтэд тарааж ажилласан. Өдөрлөгт 400 гаруй иргэд хамрагдсан байна. Мөн “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” аяныд аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 29 агентлаг, 19 сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар нэгдсэн бөгөөд зохион байгуулсан нөлөөллийн ажил арга хэмжээ, үр дүнг энэ оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор тайлагнаж ажиллах чиглэлийг өгсөн. Тус аяны хугацаанд сум, байгууллагуудын хийсэн ажлыг дүгнэж, идэвх санаачилгатай, шинэлэг ажил арга хэмжээ зохион байгуулж, үр дүнтэй ажилласан сум, агентлаг байгууллагуудыг шалгаруулж шагнаж, урамшуулахаар шийдвэрлэсэн.

Иргэд, олон нийтийг “Нээлттэй засгийн түншлэл”-ийн тухай мэдлэг, ойлголттой болгох арга хэмжээний хүрээнд аймгийн орон нутгийн Тамир телевизтэй хамтран “Нээлттэй засгийн түншлэл”-ийн тухай болон тус арга хэмжээний хүрээнд зохион байгуулж буй ажил арга хэмжээний мэдээллийг хүргэн ажилласан. Мөн аймгийн ЗДТГ-ын албан ёсны цахим хуудас www.arkhangai.gov.mn сайтад “Нээлттэй засгийн түншлэл” гэсэн цэс нэмж холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр иргэд, олон нийтэд нээлттэйгээр байршуулж ажилласан.

Холбоос: <https://arkhangai.gov.mn/category/tech/tunshlel-tech/>,
<https://www.facebook.com/100026806792879/videos/679929601662065>

“Нээлттэй засгийн сорилт: Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал” арга хэмжээг аймгийн СЕХ-тай хамтран аймгийн улс төрийн намуудын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд СЕХ-ны “Монгол улс-нээлттэй засгийн түншлэл улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах сорилт” 16 минут 40 секундын видео бичлэгийг үзүүлсэн. Мөн аймгийн МАН болон АН-ын дэд дарга нарт тус бичлэгийг намын гишүүд болон холбогдох албан хаагчдад хүргэж ажиллана уу хэмээн тус видео бичлэгийг хүргүүлэн ажилласан.

НҮБХХ-тэй хамтран зохион байгуулсан “Бизнес ба хүний эрх” сургалтад аймгийн ЗДТГ-ын удирдлагууд, мэргэжилтнүүд хамрагдсан. Тус сургалтад: Аймгийн ЗДТГ-ын дарга болон ХБТХОХ, НБХ, ХЭХ, ТЗУХ-ийн мэргэжилтнүүд оролцсон.

Холбогдох зурган файлыг хавсаргав.







Өгийнуур сумын Засаг даргын Тамгын газар · [Follow](#)

4 Jun · 🌐

#АВЛИГАГҮЙ НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА
АЯНД БИДНИЙ ЗАЛГАМЖ ҮЕ- ХҮҮХЭД
БАГАЧУУД МААНЬ НЭГДЭЖ БАЙНА. 🙏❤️💪



Insights unavailable ⓘ

Create ad

2025-06-18 4:58:50 PM

Холбоо бар

✉ өргөдөл, гомдол

🏠 АЙМГИЙН ТУХАЙ ▾ НУТГИЙН УДИРДЛАГА ▾ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ▾ ХУУЛЬ ЭРХЗҮЙ ▾ ИЛ ТОД БАЙДАЛ ▾

☰

THIS WEEK

САЛБАР ЗӨВЛӨЛ ▾ ISO9001-2015 ▾ НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ



🌐 ТОВЧ

МЭДЭЭ СОНСОЖ, ШИЙДНЭ* ӨДРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛНА

2025-04-08

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг

2025-04-04

Home » Мэдээ, мэдээлэл » НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ

Activate
Go to Settings

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ

Нээлттэй засгийн түншлэл долоо хоног-2025

👤 Gunerdene Gurjab 🕒 2025-05-20 💬 0 👍 1 Mins



Share



Tweet



Email



Share



Share

"Нээлттэй засгийн түншлэл долоо хоног-2025" арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар АГХУСАЗСЗ-тэй хамтран "Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа" соён гэгээрүүлэх сарын аяныг зарлаж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй хэн бүхэнд "ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЭЭД ӨӨРЧИЛБЭ". Авлигад үгүй гэж хэлбэ.

#Та_бүхнийг_Авлигагүй_нийгмийн_төлөө_хамтдаа_аянд_нэгдэхийг_уриалж_байна.



АРХАНГАЙ АЙМГИЙН
ТАМГА ДАРГАЙН ТАМГЫН
ГАЗАР



АРХАНГАЙ АЙМГИЙН
ТАМГА ДАРГАЙН ТАМГЫН
ГАЗАР

АВЛИГАГҮЙ НИЙГМИЙН
ТӨЛӨӨ ХАМТДАА

ОДГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАХ

► (гарчиг байхгүй)

► Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлийн 2025 оны ажиллагааны жилийн төлөвлөгөө

► "Шинэтгэлээр түүчээлсэн салбар аяны хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө

Архив

► 5 сар 2025

► 4 сар 2025

► 3 сар 2025

► 2 сар 2025

► 1 сар 2025

► 12 сар 2024

► 11 сар 2024

► 10 сар 2024

